

Хэдийгээр эх хэл нь биш боловч тухайн хэлийг өндөр түвшинд эзэмшсэн сурагч энэхүү шалгалтад оролцох боломжтой юу?

Тийм ээ, Хэрвээ тухайн сурагч шалгалт бичигдсэн хэл дээр анхан, дундаж эсвэл түүнээс дээш түвшинд уншиж, бичиж, ярьж, сонсох чадвартай бол энэхүү шалгалтад оролцох боломжтой. Өөрийгөө үнэлэх хүснэгтийг харна уу. Сурагчид бүх дасгал ажлыг бие даан гүйцэтгэх чадвартай байх ёстой.

Ямар хэлээр шалгалт өгч болох вэ?

Шалгалт өгч болох бүх хэлийг бүртгэлийн маягт дээр жагсаан бичсэн болно. Хэрвээ таны хүссэн хэл уг жагсаалтад байхгүй бол энэ удаа та уг хэлний шалгалтыг өгөх боломжгүй гэсэн үг.

Шалгалт хэзээ явагдах вэ?

Шалгалтыг 11-р сард сонгуулийн өдөр (сурагчдын амралтын өдөр) зохион байгуулах болно. Зарим шалгалтын өдөр өөр байгаа учраас сурагчид руу шууд холбогдон сар өдрийг хэлэх болно. Энэ талаар дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл <https://www.apsva.us/world-languages/credit-by-exam/credit-by-exam-faq/>-д зочилно уу.

Сурагчид хэрхэн бүртгүүлэх вэ?

Сурагчид онлайн хэлбэрээр: <https://www.apsva.us/world-languages/credit-by-exam/> хаягаар орж бүртгүүлэх боломжтой. Үүний дараа, сурагчидтай холбоо барьж, шалгалт өгөх огноо, хугацаа, байршлыг баталгаажуулах болно.

Шалгалт явагдахаас зургаан долоо хоногийн өмнө **бүртгэл** дуусах болно.

Шалгалтыг хэрхэн дүгнэх вэ?

Эдгээр шалгалтыг компьютероор эсвэл тухайн хэлээр мэргэшсэн хөндлөнгийн этгээд шалган оноожуулах болно. Шалгалтын дүнг эцсийнх гэж үзэх ба цаашид давж заалдах боломжгүй. Дараах хүснэгтэд үндэслэн кредитийг олгох болно.

Хэлний түвшин	Олгосон кредит	Дараагийн суралцах шат	SFS-ийн дараагийн шат
Суурьтайн анхан шат	1.0	II түвшин	SFS I түвшин
Дунд шат	2.0	III түвшин	SFS II түвшин
Ахисан дунд шат	3.0	IV түвшин	SFS III түвшин

Түвшин тогтоох дараагийн сонголт нь 4-р түвшний шалгалт юм.

Шалгалтад тэнцсэнээр сурагчид кредит авах уу?

Хэрвээ шалгалтыг амжилттай өгвөл сурагчид тухайн хичээлээр “тэнцсэн” гэсэн үнэлгээ авах бөгөөд дүнгийн хүснэгт дээр “P” гэсэн үнэлгээ тавигдсанаар тухайн хэлний зохих түвшнийг сурагч амжилттай дүүргэснийг илтгэх юм. Сурагчдад голч оноо (GPA) –д нь нөлөөлөхүйц үсгээр илэрхийлсэн үнэлгээ өгөхгүй болно. Тухайн хичээлийг дунд ангидаа үзээгүй л бол сурагч өмнө нь үсгээр авсан үнэлгээг “тэнцсэн” үнэлгээгээр солих боломжгүй.

Дүнг хэрхэн зарлах вэ?

Дүнгийн мэдэгдлийг 2-р сард захиагаар эцэг эхчүүдэд хүргүүлнэ.

Шалгалтаар авах кредит болон Хоёр хэл эзэмшсэнийг гэрчлэх тамга

Дэлхийн хэлний алба

2110 Washington Blvd. Утас: 703.228.6097
Arlington VA 22204 apsva.us/worldlanguages



Arlington
Public
Schools



Шалгалт өгснөөр авах кредит гэж юуг хэлэх вэ?

Арлингтоны Төрийн Өмчит Сургуулиуд (APS) англиас бусад хэл дээр ойлгох, харилцан ярих чадвартай сурагчдад сонгогдсон муж улсаас баталсан тодорхой тооны гадаад хэлний шалгалт өгөх замаар сурагчид ахлах сургуульдаа кредит авах

боломжийг олгодог. Эдгээр шалгалт нь сурагчдын дэлхийн хэлнийг чадамжийг шалгаж, гурав хүртэлх кредит өгдөг.

Шалгалт өгснөөр авах кредитийг ашиглах нь сурагчдад ямар давуу тал авчрах вэ?

Хэрвээ сурагчид Ахисан шатны сургалтын диплом (ASD)-той төгсөхийг хүсвэл гадаад хэлний кредит авах хэрэгтэй болно. Үүнийг авахын тулд нэг хэлний гурван жил/кредит (3 x 1) эсхүл хоёр өөр хэлний хоёр жил/кредит (2 x 2) авах шаардлагатай.

Шалгалт өгснөөр дэлхийн хэлний хэдэн кредит авах боломжтой вэ?

2020 оны 11-р сард шинэчлэгдсэн Хэлний Чадварын Кредитийн Виржиниагийн Боловсролын Зөвлөлийн сургалтын гарын авлагаас харахад эдгээр шалгалтыг амжилттай өгснөөр сурагчид гурав хүртэлх кредит авах боломжтой. Хэрвээ сурагч хэлний чадвараасаа хамаарч дээгүүр түвшинд орсон бол өмнөх түвшнүүдийнхээ шалгалтыг нөхөн өгч болно. Хэрвээ сурагч II түвшний ангид элсэн ороод шалгалт өгч гурван кредит авсан бол дүнгийн хуудас дээр зөвхөн нэг л кредит нэмэгдэн бичигдэх боломжтой. **Нэг ижил хэлний хичээлээс олон кредит авах боломжгүй.**

Тус шалгалтын дүн нь Виржиниагийн Хоёр

хэл эзэмшсэнийг илтгэх тамга даруулахад хэрхэн дэмжлэг болох вэ?

2015-16 оноос хойш, Виржиниагийн Боловсролын зөвлөлийн Хоёр хэл эзэмшсэнийг илтгэх тамга нь ахлан сургуулийн төгсөх ангийн сурагчид Англи хэлнээс гадна нэг буюу түүнээс дээш хэлний түвшин эзэмшсэн болохыг гэрчлэх болсон. Англи хэлний хичээлийн эцсийн шалгалтад бүрэн эзэмшсэн эсхүл түүнээс дээш түвшинд (11 дүгээр анги SOL) эзэмшсэн байдлаар бүгдэд нь тэнцэж, өөр хэлний үндэсний стандарт шалгалтад дунд шатны дундаж түвшин буюу түүнээс дээш түвшний оноо авсан сурагчдад Хоёр хэл эзэмшсэнийг илтгэх тамга өгдөг. Хоёр хэл эзэмшсэнийг илтгэх тамга нь сурагчийн ахлах сургуулийн диплом дээр дарагд.

Тус шалгалтыг хэн өгөх эрхтэй вэ? Шалгалт өгөх түвшний хэлний мэдлэг эзэмшсэн болохоо хэрхэн мэдэх вэ?

Эдгээр шалгалтыг 9-12 дугаар ангийн сурагчид өгөх эрхтэй бөгөөд хэлний мэдлэгийн түвшин нь хамгийн багадаа Анхлан суралцагчийн дунд шатанд байх ёстой бөгөөд дараах чадвартай байх ёстой:

- Энгийн хялбар асуулт асуух, хариулт өгөх.
- Өөр хүнтэй хийх харилцан ярианы хариуг энгийн хялбар өгүүлбэрээр өгөх.
- Ойр зуурын, энгийн мэдээлэл ойлгуулах.
- Дуртай, дургүй зүйлсээ илэрхийлэх.
- Энгийн хялбар анкет бөглөх.
- Өдөр тутам хийдэг зүйлсийн талаар бичих, унших.

Та <https://www.apsva.us/world-languages/credit-by-exam/credit-by-exam-faq/> хуудсан дахь CBE-нТүгээмэл Асуултын Хариулт дахь Өөрийн үнэлгээний хүснэгтийг харна уу.



Хэрвээ та англи хэлний нэмэлт хичээл үздэг буюу тус хэлээр сайн уншиж, ойлгодоггүй бол ийм үйлчилгээ авдаг тухайгаа бүртгүүлэхдээ бидэнд мэдэгдэнэ үү. Ийм тохиолдолд бид танд шалгалтын өөр материал санал болгох болно.

Эдгээр шалгалтыг хэн өгч БОЛОХГҮЙ вэ?

- IV түвшний эсхүл SFS III түвшний ангид элсэн суралцагчид хавар тус шалгалтыг өгөх учраас одоо өгөх шаардлагагүй.
- Өмнө нь гадаад хэлний хичээл дээр авсан дүнгээ сайжруулахыг хүссэн сурагчид эдгээр шалгалтыг өгөх боломжгүй болно.

Шалгалт ямар төлбөртэй вэ?

Арлингтоны Төрийн Өмчит Сургуулиудын анх удаа шалгалт өгч буй сурагчид ямар нэг төлбөр төлөхгүй. Дахин шалгалт өгөх тохиолдолд төлбөрийг сурагч өөрөө хариуцах бөгөөд шалгалтаасаа хамаараад төлбөр нь харилцан адилгүй байна. Аман ярилцлага (OPI) өгөх хуваарьт орсон сурагчид уг ярилцлагад ирэхгүй бол аман ярилцлагад (OPI)-д ирээгүйн торгууль 55 долларыг төлөх хэрэгтэй болно.

Сурагчид шалгалтад тэнцсэн бол дүн авах үү?

Хэрэв амжилттай өгсөн тохиолдолд, сурагчид дүйцүүлэх хичээл(үүд) дээрээ “тэнцсэн” гэсэн дүн авах ба дүнгийн мэдээлэл дээр “P” гэсэн тэмдэглэгээ байх бөгөөд энэ нь тухайн түвшинг амжилттай дүүргэсэн болохыг илтгэнэ. Сурагчид дүнгийн голч (GPA)-д нөлөөлөх үсгээр илэрхийлсэн дүн авахгүй.

Дүнг хэрхэн мэдэгдэх вэ?

Дүнгийн мэдэгдлийг эцэг эхчүүдэд 2-р сард захидлаар хүргүүлнэ.

Илүү дэлгэрэнгүй мэдээлэл хаанаас авах вэ?

Дэлхийн хэлний албаны 703.228.6097 утсаар хандах буюу сургуулийн зөвлөлтэй яриарай.